



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Зээлийн барьцаа шилжүүлэх
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01/339 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд байрлах "Буянт-Ухаа 2" хорооллоос бартераар төлбөрийг нь төлж орон сууц худалдан авсан 95 иргэний орон сууцыг зээлийн барьцаанаас чөлөөлөхөд зориулж, "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газрын нэр дээр үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээгээр баталгаажсан Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд байрлах "Хангай" хотхоны 223 айлын орон сууцнаас 128 айлын орон сууцыг Хөгжлийн банкны зээлийн барьцаанд шилжүүлэхийг "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ж.Хичээнгүйд зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ